



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч дахин үнэлгээнд хамрагдсан, сэргээн засварлах боломжгүй болсон нь Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2010 оны 11-29-33/424, 2017 оны 02-07-112/373 дугаар дүгнэлт актаар тогтоогдсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй нийт 758,064,279.88 (долоон зуун тавин найман сая жаран дөрвөн мянга хоёр зуун далан есөн төгрөг наян найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 708,745,727.83 (долоон зуун найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун хорин долоон төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг цогцолбороор нь акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М.Даваабат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Газрыг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээж, төрийн өмчийн эмнэлгийн барилга барихаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132001328

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
57 дугаар тогтоолын хавсралт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн
Мэргэжлийн өвчин судлалын газрын үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй ақталж, данснаас хасах хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад, бүртгэлд авсан огноо	Байршил	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Мэргэжлийн өвчин судлалын газрын Эмнэлгийн байр /цогцолбороор/ /2 давхар, нийт талбай 544 м2/	1956/ 1967	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо Төмөрчний гудамж	1	741,356,000.00	741,356,000.00	692,458,854.08	48,897,145.92
2	Бетон талбай /гадна/	1980 05.05	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо Төмөрчний гудамж	270	1,200.00	324,000.00	324,000.00	0
3	Тасалгааны вакуум хаалт	1980 05.20	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо Төмөрчний гудамж	1	11,171,780.00	11,171,780.00	11,171,780.00	0

4	Дулааны шугам	1975.05.05	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо Төмөрчний Гудамж	15	130,000.00	1,950,000.00	1,950,000.00	0
5	Төвийн төмөр хашаа	1980.07.29	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо Төмөрчний Гудамж	38	85,855.26	3,262,499.88	2,841,093.75	421,406.13
	Нийт дүн			325		758,064,279.88 (долоон зуун тавин найман сая жаран дөрвөн мянга хоёр зуун далан есөн төгрөг наян найман мөнгө)	738,745,727.83 (долоон зуун найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун хорин долоон төгрөг наян гурван мөнгө)	49,318,552.05 (дөчин есөн сая гурван зуун арван найман мянга таван зуун тавин хоёр төгрөг таван мөнгө)